



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 8/16

Шивээговь сум

**Э.Төрмандахад ур чадварын
 нэмэгдэл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гарган удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, Гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг цаг тухайд нь хангаж, санаачлагатай ажилласан Соёлын төвийн дарга Энхтөрийн Төрмандахад үндсэн цалингийн 25%-иар ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Э.Төрмандахад олгох нэмэгдлийг Цалингийн зардлаас дээр дурдсан хувиар бодож олгохыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ